



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 08 дугаар сарын 19
№ 31 /940/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

1757

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

1759

**Шүүхийн ёс зүйн хорооны
гишүүнийг томилох тухай**

**Хувьсах зардлын дундаж
норматив, санхүүжүүлэх
аргачлал батлах тухай**



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

605.	Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 111	1757
606.	Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнийг томилох тухай	Дугаар 112	1757
607.	Шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 113	1758
608.	Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 114	1758

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

609.	Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай	Дугаар 242	1759
------	---	------------	------

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 08 дугаар сарын 08-ны өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Норлоогийн Эрдэнэцогт, Намжилийн Чинбат, Хуягийн Номингэрэл, Одонхүүгийн Мөнхсайхан, Бийцээгийн Үнэнбат, Сандагийн Нямжав нарыг Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 08 дугаар сарын 08-ны өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4, 32.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Норлоогийн Эрдэнэцогт, Одонхүүгийн Мөнхсайхан, Алтангэрэлийн Доржготов нарыг Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 08 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 113

Улаанбаатар
хот

**Шүүхийн шүүгчийн албан тушаалаас
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Жамьянчойжилын Сэмжидийг Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 08 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 114

Улаанбаатар
хот

**Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Жамьянчойжилын Сэмжидийг Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Сугарын Болортуяаг Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 242

Улаанбаатар
хот

Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 40.2, 40.3, 40.5, 41.3, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг 2 дугаар хавсралт, төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг 3 дугаар хавсралт, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг 4 дүгээр хавсралт, төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг 5 дугаар хавсралт, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлалыг 6 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативт зардлыг батлагдсан аргачлалын дагуу санхүүжүүлж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Болор, бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Зардлын дундаж норматив батлах тухай” Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 94 дүгээр тогтоолын 1, 2 дугаар хавсралт, 3 дугаар хавсралтын 1 дэх заалт болон 2 дахь заалтын “Ерөнхий боловсролын сургууль” гэсэн хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ГАНТӨМӨР



Засгийн газрын 2016 оны 242 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛ
ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ
ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВЫГ ТООЦОХ БҮРЭЛДЭХҮҮН**

№	ҮЗҮҮЛЭЛТ	
1	Багшийн албан тушаалын цалин болон нэмэгдэл цалин, хүүхдийн цэцэрлэг, дотуур байрны багш, ажилтны албан тушаалын цалин болон зарим нэмэгдэл (Зарим нэмэгдэл гэдэгт: цалин, хөдөө орон нутагт ажилласан, ур чадварын, анги кабинет болон заах аргын нэгдэл хариуцсан нэмэгдлийг ойлгоно)	
2	Багшийн үндсэн болон нэмэгдэл цалинд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	
3	Бараа, үйлчилгээний бусад хувьсах зардал	1. Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх
		2. Бичиг хэрэг
		3. Ном, хэвлэл
		4. Шуудан холбоо, интернэтийн төлбөр
		5. Дотоод албан томилолт
		6. Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс
		7. Нормын хувцас, зөөлөн эдлэл
		8. Эм бэлдмэл
		9. Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчийн устгал, ариутгал
		10. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж

Засгийн газрын 2016 оны 242 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ
СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН
ДУНДАЖ НОРМАТИВЫН ХЭМЖЭЭ**

(мян.төг)

№	Байршил	Цалин	Ажил олгогчийн төлөх шимтгэл	Бусад хувьсах зардал	Нийт хувьсах зардал
1	Аймгийн төвөөс бусад сумын	874.1	96.2	27.9	998.2
2	Аймгийн төвийн	709.2	78.0	25.1	812.3
3	Нийслэлийн	707.3	77.8	22.8	807.8

Засгийн газрын 2016 оны 242 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
БАГА, ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ
ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВЫН ХЭМЖЭЭ**

(мян. төг)

Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив											
Байршил	Сургуулийн ангилал	Багшийн цалин			Ажил олгогчийн төлөх шимтгэл			Бусад хувьсах зардал	Нийт хувьсах зардал		
		бага анги	дунд анги	ахлах анги	бага анги	дунд анги	ахлах анги		бага анги	дунд анги	ахлах анги
	Багийн бага сургууль	576.8			63.5			42.8	683.1		
Аймгийн төвөөс бусад сум	Суурь боловсролын сургууль	309.0	481.0		34.0	52.9		21.9	364.9	555.9	
	Бүрэн дунд боловсролын сургууль	288.3	417.0	438.8	31.7	45.9	48.3	14.6	334.6	477.5	501.7
Аймгийн төвийн болон нийслэлийн захын дүүрэгт	Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургууль	271.6	392.7	400.4	29.9	43.2	44.0	13.9	315.4	449.8	458.4
Нийслэлийн	Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургууль	246.7	355.1	373.6	27.1	39.1	41.1	13.1	286.9	407.3	427.8



Засгийн газрын 2016 оны 242 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ
НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ
НОРМАТИВЫН ХЭМЖЭЭ**

(мян.төг)

№	Дотуур байрны хэв шинж	Цалингийн зардал	Ажил олгогчийн төлөх шимтгэл	Бусад хувьсах зардал	Дотуур байрны нийт хувьсах зардал
1	Ерөнхий боловсролын сургуулийн 6 настай хүүхэд амьдардаг дотуур байр	402.8	44.3	15.0	462.2
2	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр	268.2	29.5	15.0	312.7

Засгийн газрын 2016 оны 242 дугаар
тогтоолын 5 дугаар хавсралт

**ТӨРИЙН БУС ӨМЧИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ
ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВЫН ХЭМЖЭЭ**

(мян.төг)

Нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хэмжээ	Байршил	Нормативт зардлын хэмжээ		
		Бага анги	Дунд анги	Ахлах анги
Төлбөргүй болон 5,000,000.0 төгрөг хүртэлх төлбөртэй	орон нутгийн	316.4	450.8	459.3
	нийслэлийн	288.9	409.3	429.8
5,000,001.0-ээс 10,000,000.0 төгрөг хүртэлх төлбөртэй	орон нутгийн	189.8	270.5	275.6
	нийслэлийн	173.3	245.6	257.9



10,000,001.0 төгрөгөөс дээш төлбөртэй	орон нутгийн	94.9	132.2	137.8
	нийслэлийн	86.7	122.8	128.9

Засгийн газрын 2016 оны 242 дугаар
тогтоолын 6 дугаар хавсралт

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛ
ЭЗЭМШҮҮЛЭХ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ДОТУУР БАЙРНЫ НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ
ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВААР САНХҮҮЖҮҮЛЭХ
АРГАЧЛАЛ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төсвийн ерөнхийлөн болон төсвийн төвлөрүүлэн захирагчаар дамжуулан төрийн болон орон нутгийн өмчит, төрийн бус өмчит ерөнхий боловсролын сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативаар санхүүжих төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү аргачлалыг ашиглана.

1.2. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативаар санхүүжүүлэх аргачлалыг Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн хүрээнд хэрэглэнэ.

1.3. Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгт улсын төсвөөс хувьсах зардлын нормативын санхүүжилтийг тухайн боловсролын сургалтын байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, боловсролын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, төсвийн төсөлд өгсөн саналыг үндэслэн олгоно.

Хоёр. Нэр томьёо

2.1. Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “хувьсах зардлын дундаж норматив” гэж сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх байгууллагын хүүхдийн



тооноос шууд хамааралтайгаар өөрчлөгдөх зардлын нэг хүүхдэд ногдох хэмжээг;

2.1.2. “сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллага” гэж Боловсролын тухай хуулийн 14.1-д заасныг;

2.1.3. “санхүүжих дундаж хүүхдийн тоо” гэж сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцоход ашиглан батлагдсан аргачлалын дагуу төсвийн жилд харгалзуулан тооцсон хүүхдийн тоог;

2.1.4. “албан бус боловсрол” гэж Боловсролын тухай хуулийн 3.1.7-д заасныг;

2.1.5. “нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив” гэж сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн тооноос хамааруулан нийт хэмжээ нь өөрчлөгдөх зардлыг;

2.1.6. “хүүхэд өдөр” гэж тодорхой хугацааны нийт өдөрт хамрагдах хүүхдийн тооны үржвэрийг;

2.1.7. “олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль” гэж Боловсролын тухай хуулийн 3.1.13-т заасныг;

2.1.8. “ерөнхий боловсролын лаборатори сургууль” гэж Боловсролын тухай хуулийн 3.1.14-т заасныг;

2.1.9. “төрөлжсөн сургалт” гэж Бага, дунд боловсролын тухай хуулийн 14.1-д заасныг;

2.1.10. “төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн сургалтын төлбөр” гэж тухайн сургуулийн зөвлөлийн шийдвэрээр баталгаажсан хөнгөлөлт, чөлөөлөлт тооцогдоогүй нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг;

Гурав. Төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, өмчийн хэлбэр үл харгалзан хүүхдийн цэцэрлэгийн хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилт

3.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын албан сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж

нормативын бараа, үйлчилгээний бусад хувьсах зардалд эдийн засгийн ангиллын эзлэх хувь хэмжээг төсвийн шууд захирагчийн саналыг үндэслэн төсвийн төвлөрүүлэн захирагч, төвлөрүүлэн захирагчийн саналыг үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагч боловсруулна.

3.2. Сургуулийн өмнөх боловсролын албан сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын цалингийн санд багш, ажилтнуудын үндсэн болон бусад нэмэгдэл, сургалтын байгууллагын байршлаас хамаарсан орон нутгийн нэмэгдэл, тэдгээрт ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл багтана.

3.3. Ерөнхий боловсролын албан сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын цалингийн санд багшийн үндсэн болон сургалтын байгууллагын байршлаас хамаарсан орон нутгийн нэмэгдэл, анги бүлэг, заах аргын нэгдэл, кабинет хариуцан ажилласны нэмэгдэл, тэдгээрт ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл багтана.

3.4. Санхүүжих дундаж хүүхдийг тооцохдоо дараах аргачлалыг ашиглана. Санхүүжих дундаж хүүхдийн тоог хүүхдийн цэцэрлэгт нийт санхүүжих хүүхдийн тоогоор; ерөнхий боловсролын сургуульд бага, дунд, ахлах ангиар нь дараах аргачлалаар тус тус тооцон гаргана.

$$AFP_i = \frac{(P_{(i-1,i)} * 6 \text{ сар} + P_{(i,i+1)} * 4 \text{ сар})}{10 \text{ сар}}$$

AFP_i = i онд санхүүжих хүүхдийн тоо

$P_{(i-1,i)}$ = $(i - 1, i)$ буюу өмнөх оны хичээлийн жилийн хүүхдийн тоо

$P_{(i,i+1)}$ = $(i, i + 1)$ буюу дараагийн хичээлийн жилийн хүүхдийн тоо

3.5. Баян-Өлгий аймгийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын албан сургалтад хамрагдаж байгаа нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын цалин, түүнд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 4 хувиар, бараа, үйлчилгээний бусад хувьсах зардлыг 3 хувиар тус тус нэмэгдүүлэн тооцно.

3.6. Хүүхдийн цэцэрлэгийн хувилбарт сургалтын ээлжийн бүлэгт хамрагдах нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын цалин, түүнд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 60 хувийг, бараа, үйлчилгээний бусад хувьсах зардлын 50 хувийг тус тус олгоно.

3.7. Хүүхдийн цэцэрлэгийн хувилбарт сургалтын нүүдлийн бүлэгт хамрагдах нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын цалин,



түүнд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 70 хувийг, бараа, үйлчилгээний бусад хувьсах зардлын 50 хувийг тус тус олгоно.

3.8. Хүүхдийн цэцэрлэгийн хувилбарт сургалтын явуулын багшийн сургалтад хамрагдах нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын цалин, түүнд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 60 хувийг, бараа, үйлчилгээний бусад хувьсах зардлын 50 хувийг тус тус олгоно.

3.9. Хүүхдийн цэцэрлэгийн 24 цагийн үйлчилгээнд хамрагдах нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын цалин, түүнд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 50 хувиар, бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг 4 хувиар тус тус нэмэгдүүлж олгоно.

3.10. Ерөнхий боловсролын албан бус (дүйцсэн болон бичиг үсгийн) сургалтад хамрагдах нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын цалин, түүнд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 70 хувийг, бараа, үйлчилгээний бусад хувьсах зардлын 80 хувийг тус тус олгоно.

3.11. Төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн санхүүжих дундаж хүүхдийн тоо болон хувьсах зардлын дундаж нормативаар тооцсон цалингийн сангийн хэмжээ нь тооцсон цалингаас 30 болон түүнээс дээш хувиар хэтэрсэн тохиолдолд дээд шатны төсвийн захирагч тухайн байгууллагын цалингийн санг бодит цалингаар нь тооцон зохицуулалт хийж болно.

3.12. Сургалтын нормативт зардлын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу сар тутам олгоно.

Дөрөв. Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн
нэг суралцагчид ногдох хувьсах зардлын
дундаж нормативын санхүүжилт

4.1. Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтийг төсвийн жилээр төлөвлөж, шат шатны төсвийн захирагчийн төсвийн төсөлд тусгана.



4.2. Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургалтын байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, сургалтын төлбөр тогтоосон шийдвэрийн албан ёсны хуулбар нь төсвийн төслийн салшгүй хэсэг байна.

4.3. Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцохдоо Төсвийн тухай хуульд заасан төсвийн төсөл боловсруулах цаглабарын хугацаанд тухайн жилийн төсвийн төсөлтэй хамт ирүүлсэн сургалтын төлбөр тогтоосон шийдвэрийг баримтална.

4.4. Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын төлөвлөлт, хуваарилалт, санхүүжилт, хяналтыг санхүүжих дундаж хүүхдээр тооцно. Санхүүжих дундаж хүүхдийн тоо нь тухайн хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээлэл дэх хүүхдийн тоо болон сургалт эрхлэх тусгай зөвшөөрлөөр баталсан хүүхдийн тооноос ихгүй байна.

4.5. Хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу улирал тутам олгоно.

Тав. Төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилт

5.1. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив нь багш, ажилтны үндсэн болон зарим нэмэгдэл цалин, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний бусад хувьсах зардлаас бүрдэнэ.

5.2. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бараа, үйлчилгээний бусад хувьсах зардал нь дараах эдийн засгийн ангиллаас бүрдэнэ:

5.2.1. бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйл худалдаж авах зардал;

5.2.2. эм бэлдмэл

5.2.3. нормын хувцас, зөөлөн эдлэл худалдаж авах зардал;

5.2.4. урсгал засвар.

5.3. Хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу сар тутам олгоно.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0,75

Индекс: 14003